



LEGAL NEWSLETTER

2025 January №52

AKP Law Firm

Бид энэ оны 1 дүгээр сард батлагдсан Хууль, онцлох УИХ-ын тогтоол болон энэ сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн хууль, тогтоол, нэмэлт өөрчлөлтийг танилцуулж байна.

I. ХУУЛЬ:

2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр нэг хууль батлагдсан байна.

1.1. ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ БАЙГУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭГ ЗӨВШИЛЦӨХ ДЭГИЙН ТУХАЙ хууль

2024 оны 11 дүгээр сарын 21-ний УИХ-ын намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар **Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг** яаралтай горимоор хэлэлцэн баталсан.

Ингэснээр стратегийн ач холбогдол бүхий ордуудыг ашиглах, өндөр технологи нэвтрүүлэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тэр дундаа **Дорноговь аймгийн Улаанбадрах суманд хэрэгжих Монгол, Францын хамтарсан “Зөөвч-Овоо” ураны төслийн Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн.**

Улмаар **Францын төрийн өмчит “Орано майнинг” групптэй байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээг УИХ-аар хэлэлцэх ажил үлдсэн.** Хөрөнгө оруулалтын гэрээгээр дамжуулаад хөрөнгө оруулагч талд ч, Монголын талд ч хэрхэн харилцан ашигтай байхыг эцэслэн шийдвэрлэх боломжийг хангах зорилгоор энэхүү дэгийн тухай хуулийг баталсан.

II. УИХ-ЫН ТОГТООЛ:

2025 оны 1 дүгээр сард нийт 14 УИХ-ын тогтоол батлагдсан ба тэдгээрээс дараах тогтоолуудыг онцолж байна.

2.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТУХАЙ (02 дугаар тогтоол)

Монгол Улсын Засгийн газраас Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Францын “Орано Майнинг” компанийн хооронд байгуулах **хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөнд тооцох тухай тогтоол** баталлаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо уг гэрээг Засгийн газарт гарын үсэг зурахыг зөвшөөрөх санал гаргаж, **гишүүдийн 79.3 хувь нь дэмжжээ.**

2.2. СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭГ ОРЛУУЛАХ ТУХАЙ (01 дүгээр тогтоол)

Дорноговь аймгийн Улаанбадрах суманд үйл ажиллагаа явуулах гэж буй “Бадрах Энержи” ХХК-ийн төрийн эзэмшлийн **34 хувийн хувьцааг** өөрчлөх шийдвэр гаргажээ.

Тодруулбал, уг хувьцааг:

- 24 хувийг** “Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр”
- 10 хувийг** “Давуу эрхийн хувьцаа” болгож хөрвүүлэхээр болжээ.

10 хувийг Давуу эрхийн хувьцаа болгож буй асуудал дээр Давуу эрхийн хувьцаа нь Энгийн хувьцаанаас ямар ялгаатайг тайлбарлавал:

Энгийн хувьцаа	Давуу эрхийн хувьцаа
Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар санал өгөх эрхтэй.	Зөвхөн давуу эрхийн хувьцаатай холбоотой санал өгөх эрхтэй.
Давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг төлсний дараа, компаниас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашиг авна.	Ногдол ашгийг тэргүүн ээлжид тогтмол авна.
Компани татан буугдсаны дараа эд хөрөнгийг худалдаалснаас олсон орлогоос ногдох хувиа давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн дараагаар авна.	Компани татан буугдсаны дараа эд хөрөнгийг худалдаалснаас олсон орлогоос нэн тэргүүнд ногдох хувиа хүртэнэ.

Үлдсэн 24%-ийг "Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр" хэлбэрээр авах юм. Чингэхдээ тус хувь хэмжээг доорх байдлаар гаргажээ:

Ураны хүдрийн баяжмал (ураны исэл U3O8)-ын зах зээлийн үнэ (ам.доллар/фунт)	Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ
0-40 хүртэл	0.0%
40-50 хүртэл	0.5%
50-аас дээш	5.0%

Ерөнхийдөө Монгол, Францын хамтарсан цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Бадрах Энержи" ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулахаар болсон нь **"Төр компанийн удирдлагад шууд оролцох хувь хэмжээг багасгаж, харин тогтмол орлого авах хэлбэрийг сонгож байна"** гэж ойлгож болно.

III. ХУУЛЬ, ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ:

Доорх хууль, тогтоолын хэрэгжилт, нэмэлт өөрчлөлт 2025 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн байна.

1	Тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлнэ
2	Төрийн албан хаагчдын цалинг 6 хувиар нэмэгдүүлнэ
3	Төрийн албан хэргийг кирил болон үндэсний монгол бичгээр хөтөлнө
4	Автобусаар зорчихдоо 1000 төгрөг төлнө
5	Ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийг зөвшөөрөлгүй зарцуулбал хорих ял онооно
6	Зэвсэгт хүчин, хилийн цэргийн онцгой нөхцөлийн нэмэгдэл 10-25 хувь болно
7	Одонтой ээжид олгодог мөнгөн тусламжийн хэмжээ 2 дахин нэмэгдэнэ
8	Органик хүнсний тухай хууль хэрэгжиж эхэлнэ

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5-р хороо, Pearl tower А блок 902 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 9511-3680